

БАТЛАВ.  
БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА   
Л.ЦЭДЭВСҮРЭН

2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр

ТЭРГҮҮЛЭХ БОЛОН ЭРЭЛТТЭЙ МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ (ХӨТӨЛБӨР)-ИЙГ  
ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛ БОЛОВСРУУЛАХ, ТЭРГҮҮЛЭХ БОЛОН ЭРЭЛТТЭЙ  
ХӨТӨЛБӨРИЙГ ТОДОРХОЙЛОХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН  
ДААЛГАВАР

**Зөвлөх үйлчилгээний нэр:** Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл (хөтөлбөр)-ийг тодорхойлох аргачлал боловсруулах, тэргүүлэх болон эрэлттэй хөтөлбөрийг тодорхойлох

**Гэрээний төрөл:** Хуулийн этгээд

**Хэрэгжүүлэх байгууллага:** Боловсрол, шинжлэх ухааны яам

**Даалгаврын хугацаа:** 3 сар

Сонирхсон этгээд мэдүүлгээ 2023 оны 11-р сарын 25 -ны өдрийн 17 цаг 00 минутын дотор ирүүлнэ үү.

Монгол, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-44, Засгийн газрын III байр,  
Утас: 51 - 262227, Факс: +976-323158

Имэйл хаяг: [letter@mecs.gov.mn](mailto:letter@mecs.gov.mn)

Веб сайт: <https://www.meds.gov.mn>

## 1. ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ:

Боловсролын ерөнхий хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.3 дахь хэсэгт "Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийг тодорхойлох аргачлал, жагсаалтыг таван жил тутам шинэчлэн боловсруулж, батлуулах"-аар тусгасан.

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого болон бусад төрөөс баримталж буй хөгжлийн бодлогуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах боловсон хүчинийг үе шаттайгаар бэлтгэхэд мэргэжилтэй ажиллах хүчин нэн шаардлагатай байна. Тэргүүлэх болон эрэлттэй дээд боловсролтой мэргэжилтнийг бэлтгэхэд төрөөс төрөл бүрийн санхүүгийн болон зохион байгуулалтын арга хэмжээг авч эхлээд байна. Боловсролын зээлийн сан нь хөгжлийн тэргүүлэх дээд боловсролын мэргэжлийн чиглэлээр суралцаж буй суралцагчдад оюутны хөгжлийн тэтгэлэг олгож байна.

Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн “Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл батлах тухай” 115 дугаар тогтоолын 1 дүгээр заалтаар “Монгол улсыг хөгжүүлэхэд шаардлагатай дээд боловсролын мэргэжлийн тэргүүлэх чиглэл”, “Дээд боловсролын эрэлттэй мэргэжлийн чиглэл”-ийг тус тус баталсан. Цаашид Боловсролын ерөнхий хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.3 дахь хэсэгт “Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийг тодорхойлох аргачлал, жагсаалтыг таван жил тутам шинэчлэн боловсруулж, батлуулах”-аар тусгасан бөгөөд тэргүүлэх болон эрэлттэй хөтөлбөрийг тодорхойлох математик аргачлал боловсруулах зайлшгүй шаардлага үүсээд байна.

Уг тогтоолын 2 дугаар заалтаар тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлээр их, дээд сургуульд суралцагч элсүүлэх хяналтын тоо, элсэлтийн босго оноо, суралцагчид зээл олгох хяналтын тоог тогтооход баримтлах аргачлалыг боловсруулан баталж, мөрдүүлэхээр заасан.

## 2. АЖЛЫН ЗОРИЛГО

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Монгол улсыг хөгжүүлэхэд шаардлагатай мэргэжлийн тэргүүлэх чиглэл болон төрөөс дэмжлэг үзүүлэх шаардлагатай эрэлттэй мэргэжлийн чиглэлийг бүх түвшинд тодорхойлох математик аргачлал боловсруулах, уг аргачлалын хүрээнд тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн чиглэлийн саналыг тодорхойлон гаргах, тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлээр их, дээд сургуульд суралцагч элсүүлэх хяналтын тоо, элсэлтийн босго оноо, суралцагчид зээл олгох хяналтын тоог тогтооход баримтлах аргачлалыг боловсруулах зорилготой.

## 3. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь дараах хүрээг хамарна.

- Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл тодорхойлох олон улсын арга, аргачлалыг судлах, харьцуулсан судалгаа хийх;
- Дээд боловсролын салбарт хэрэгжиж буй хөтөлбөр, тэдгээр хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчдын мэдээлэлд дүн шинжилгээ хийх;
- Монгол улсын хөгжилд нэн шаардлагатай байгаа ажиллах хүчний ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох, шаардлагатай боловсон хүчний тоог тодорхойлох;
- Сургалтын байгууллагуудад суралцагч элсүүлж буй хяналтын тоонд шинжилгээ хийх, элсүүлэх суралцагчийн хяналтын тоог тодорхойлоход баримтлах зарчим боловсруулах;
- Оюутны хөгжлийн тэтгэлэг олгохоор төлөвлөгдсөн санхүүжилт, түүний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, цаашид хөтөлбөр бүрд олгох тэтгэлгийн хяналтын хэмжээг тогтоох боломжийн судалгаа хийх;

## 4. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Шаардлагатай тохиолдолд аливаа асуудлаар захиалагч байгууллагын удирдлагатай харилцана. Ажлын ерөнхий зорилго болон хүрээг өөрчлөхгүйгээр

харилцан зөвшилцсөний үндсэн дээр энэхүү ажлын удирдамжид өөрчлөлт оруулж болно.

## **5. АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

Зөвлөх үйлчилгээний хүрээд дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлийг бүх түвшинд тодорхойлох математик аргачлал боловсруулж ирүүлэх;
- Аргачлалтай уялдуулан тэргүүлэх болон эрэлттэй хөтөлбөрийн санал боловсруулж ирүүлэх;
- Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлээр дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх тоо, элсэлтийн босго оноо тодорхойлох аргачлал боловсруулж ирүүлэх;
- Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлээр суралцах суралцагчид олгох зээлийн хяналтын хэмжээг тогтооход баримтлах математик аргачлал боловсруулж ирүүлэх;

## **6. ТАВИГДАХ ШААРДЛАГА**

Зөвлөх үйлчилгээний багт дараах шаардлага тавигдана. Үүнд:

1. Зөвлөх үйлчилгээний багийн гишүүд нь дээд боловсролын чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байх;
2. Багийн бүрэлдэхүүнд 5-с доошгүй докторын зэрэгтэй эрдэмтэн үүнээс 1 ба түүнээс дээш гишүүн боловсролын судлалын чиглэлээр докторын зэрэгтэй байх;
3. Багийн гишүүд нь судалгааны тогтсон арга зүй, арга барилтай байх, дээд боловсролын чиглэлээр судалгаа хийж байсан туршлагатай байх;
4. Сүүлийн 3 жилд сургалтын хөтөлбөр болон хөдөлмөрийн зах зээлийн талаар судалгаа хийж байсан бол давуу тал болно.

## **7. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН**

Энэхүү зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрсэн байна.

Үүнд:

1. Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлийг бүх түвшинд тодорхойлох математик аргачлал боловсруулсан байна.
2. Аргачлалтай уялдуулан тэргүүлэх болон эрэлттэй хөтөлбөрийн жагсаалт гарсан байна.
3. Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлээр дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх тоо, элсэлтийн босго оноо тодорхойлох аргачлал боловсруулсан байна.
4. Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлээр суралцах суралцагчид олгох зээлийн хяналтын хэмжээг тогтооход баримтлах математик аргачлал боловсруулсан байна.

## **8. АЖЛЫН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА**

Энэхүү зөвлөх үйлчилгээг 3 сарын хугацаанд хийж гүйцэтгэнэ.

<b>№</b>	<b>Гүйцэтгэх ажил</b>	<b>Хугацаа</b>
1	Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлийг бүх түвшинд тодорхойлох математик аргачлал боловсруулах	Хуанлийн 45 хоног
2	Аргачлалтай уялдуулан тэргүүлэх болон эрэлттэй хөтөлбөрийн жагсаалт гаргах	Хуанлийн 15 хоног
3	Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлээр дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх тоо, элсэлтийн босго оноо тодорхойлох аргачлал боловсруулах	Хуанлийн 15 хоног
4	Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлээр суралцах суралцагчид олгох зээлийн хяналтын хэмжээг тогтооход баримтлах математик аргачлал боловсруулах	Хуанлийн 15 хоног

## 9. ТӨСӨВТ ӨРТӨГ

Энэхүү зөвлөх үйлчилгээний төсөвт өртөг нь 65.000.000 /жаран таван сая/ төгрөг байна.

## 10. ТАЙЛАГНАХ

Зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгч нь даалгаврын гүйцэтгэл 50 хувь хүрмэгч гүйцэтгэлийн явцын тайланг захиалагчид танилцуулна. Эцсийн тайланг зөвлөх үйлчилгээ үзүүлэх нийт хугацаанаас хойш 14 хоногийн дотор захиалагч тал хангалттай хэмээн хүлээн авч, гүйцэтгэлийн актад гарын үсэг зурж, баталгаажуулснаар гэрээ дуусгавар болно.